



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2025 оны  
12 дугаар сарын 23-ны өдрийн 01/370 тоот  
албан бичгийн нэгдүгээр хавсралт

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН 2025 ОНЫ  
"ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт	Авбал зохих оноо	Оноо	Хувийн жин
1	2	3	4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлтэй нийцүүлэн баталсан эсэх	1	1	100
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөлд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх	1	1	100
3	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх	0.5	0.5	100
3		Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал	0.5	0.5	100
		Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	0.5	0.5	100
		Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал	0.5	0.5	100
<b>Хэсгийн оноо</b>					
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх	4	4	100
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал	1	1	100
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал	1	1	100
<b>Хэсгийн оноо</b>					
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал	3	3	100
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал	1	1	100
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж тайлагнасан байдал	1	1	100
<b>Хэсгийн оноо</b>					
<b>Үнэлгээний нийт оноо, хувь</b>					
			3	3	100
			10	10	100

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН  
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН<sup>1</sup>

**НЭГ. Товч танилцуулга<sup>2</sup>**

Монгол Улсын Их хурлын 2023 оны "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэг, Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 1.4-д заасныг үндэслэн тус хүрээлэнгийн Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг 5 гишүүнтэй байхаар журамд заасны дагуу хүрээлэнгийн нийт албан хаагчдын санал хураалтын дүнг үндэслэн Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг 2024 оны 7 дугаар сарын 01-ны өдрийн А/34 дугаартай тушаалын хавсралтаар баталсан.

Ёс зүйн дэд хорооны хурлаар дарга, нарийн бичгийн даргыг сонгож үйл ажиллагаагаа явуулж байна. 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хурлаар 2024 оны тайланг хэлэлцэж, 2025 онд хэрэгжүүлэх ажлыг 3 бүлэг, 11 хэсэгтэй төлөвлөж Ёс зүйн дэд хорооны дарга /Эрдэмтэн нарийн бичгийн дарга/ баталсан.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар тус хүрээлэнгийн ёс зүйн дэд хорооны гишүүнийг нөхөн сонгох үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан 2 гишүүнийг нөхөн сонгох арга хэмжээг зохион байгуулж, 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн А/23, 2025 оны 07 дугаар сарын 09-ий өдрийн А/34 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хорооны тушаалд өөрчлөлт оруулан Хууль зүйн сургалт, судалгааны төвөөс 2, Захиргаа, удирдлагын хэлтсээс сонгогдсон 3 гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Ёс зүйн дэд хороо нь холбогдох хууль, журмын хүрээнд байгууллагын албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хараат бусаар хянан шийдвэрлэх чиг үүрэгтэйгээр шударга, ил тод, нууцлалыг хангасан зарчмаар байгууллагын ёс зүйн соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

**ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай  
хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар**

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт<sup>3</sup>:

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд ёс зүйн сургалт, мэдээлэл, зөвлөмж, дотоод

<sup>1</sup> Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

<sup>2</sup> Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

<sup>3</sup> Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

хяналт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, байгууллагын ёс зүйн соёлыг төлөвшүүлэхэд чиглэж ажилласан.

Ёс зүйн хорооны 2025 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу нийт албан хаагчдаас Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлалыг ашиглан байгууллагын хэмжээнд ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээг хийж, дүнг үндэслэн эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний хяналтын хуудсыг гаргасан. Ёс зүйн хорооны 07 дугаар тогтоолоор батлагдсан Ёс зүйн нөлөөллийн мэдүүлгийг албан хаагчдаас гаргуулж ажилласан. Мөн хорооны 08 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, хариуцлагын бүртгэлийн хуудас"-ыг хэвлэн авсан, Хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо системд дэд хорооны бүрэлдэхүүний хөдөлгөөнийг бүртгэн ажиллаж байна.

"Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"/2024-2030/-ийн хэрэгжилтийг Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 04 дүгээр тогтоолоор баталсан "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт"-д тусгагдсан зорилт, арга хэмжээний хүрээнд нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/403 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

## 2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахин мөрдөж, шударга, ил тод, хариуцлагатай шийдвэр гаргалтаар үлгэрлэн манлайлж ажилласан.

Ингэснээр байгууллагын ёс зүйн соёл, сахилга хариуцлага бэхжиж, албан хаагчдын итгэл, хамтын ажиллагаа сайжрах нөхцөл бүрдсэн.

## 2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрүүдэд "Эерэг харилцаа-Эрүүл орчин", "Эрүүл бие-инээд баясал" аяныг нийт албан хаагчдын дунд эрүүл мэнд, биеийн дархлаа, сэтгэлийн эрүүл байдлыг дэмжих, инээд баясал, эерэг харилцааг нэмэгдүүлэх, ёс зүйн соёлыг бэхжүүлэх зорилгоор 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн хорооны гишүүн, доктор (Ph.D), дэд профессор М.Цэрэнбат 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр "Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд", "Стресс менежмент",

Filo Bianco LLC marketing seniour Kreativ Arc Studio& Agency Founder багш Б.Үенч 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдөр "Харилцааны соёл ба хамт олны эрүүл орчин",

Ёс зүйн сургагч багш, "Далд оршихуй" НҮТББ-ын тэргүүн, хүний их эмч Б.Пүрэвжав 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр "Эрүүл оршихуй ба ёс зүй" сургалтыг тус тус орж нийт албан хаагчид хамрагдсан.

2025 оны 12 дугаар сарын 01-ээс 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрүүдэд Монгол Улсын Ёс зүйн хороо,

Удирдлагын академийн хамтран зохион байгуулсан "Ёс зүйн сургагч багш бэлтгэх" сургалтад ёс зүйн дэд хорооны гишүүн, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга хамрагдаж, гэрчилгээ авсан.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Албан хаагчдын дунд эрүүл мэнд, биеийн дархлаа, сэтгэлийн эрүүл байдлыг дэмжих, инээд баясал, эерэг харилцааг нэмэгдүүлэх, ёс зүйн соёлыг бэхжүүлэх зорилгоор 2 удаа аян зохион байгуулж ажилласнаар тус хүрээлэнгээс 2025 онд ёс зүйн зөрчилд холбогдсон албан хаагч байхгүй болно.	
Санал:	
Саналгүй	

**Шалгах хэсэг:**

- “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

**БАТАЛГААЖУУЛАЛТ:**

Томилох эрх бүхий албан тушаалтан

ХЗЧХЗолцрвал  
/Албан тушаал/

[Signature]  
/Гарын үсэг/



Ёс зүйн дэд хорооны дарга

[Signature]  
/Албан тушаал/

[Signature]  
/Гарын үсэг/

[Signature]  
/Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

[Signature]  
/Албан тушаал/

[Signature]  
/Гарын үсэг/

[Signature]  
/Гарын үсгийн тайлал/

2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр